



ЗОГСОЛТГУЙ ХӨГЖИЖ, АМЖИЛТААРАА ЯЛГАРЪЯ

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2018 оны
II улирлын байдлаар

АГУУЛГА

03-06 КОМПАНИЙН ЕРӨНХИЙ ТАНИЛЦУУЛГА

Гүйцэтгэх захирлын мэндчилгээ
Манай хамт олон
Бүтэц зохион байгуулалт

07-13 КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

Засаглалын тогтолцоо
Хувьцаа эзэмшигчид
Хувьцаа эзэмшигчдийн хурал
Төлөөлөн удирдах зөвлөл
Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн
Эрх бүхий албан тушаалтнууд

14-26 БИЗНЕСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Онцлох үйл явдлууд
Компанийн 2023 он хүртэлх дунд хугацааны стратегийн зорилт
Төлөвлөгөө 2018 он
Бүтээгдэхүүн, үйлчилгээ

17-31 САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Орлогын дэлгэрэнгүй тайлан
Өмчийн өөрчлөлтийн тайлан
Мөнгөн гүйлгээний тайлан
Санхүүгийн шинжилгээ

32-33 ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ БА КОМПАНИЙН ХУВЬЦАА

Хувьцааны арилжаа
Хувьцааны шинжилгээ

КОМПАНИЙН ЕРӨНХИЙ ТАНИЛЦУУЛГА

Компанийн оноосон нэр	Айтүүлс ХК
Үйл ажиллагааны чиглэл	Програм хангамжийн үйлчилгээ, Мэдээллийн технологийн үйлчилгээ, Гадаад худалдаа
Компанийн албан ёсны хаяг	Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Бага тойруу-49, Мэдээлэл Технологийн Үндэсний Парк, 103 тоот Утас: (976)-7575 5585 Вэб сайт: www.itools.mn Санхүү: accountant@itools.mn Санал хүсэлт: info@itools.mn
Компанийн удирдлага	ТУЗ-ийн дарга Адилбиш овогтой БАТТАМИР Гүйцэтгэх захирал Баярсайхан овогтой ТАМИР
Үүсгэн байгуулагдсан огноо	2011 он 4-р сарын 11
Ажилтны тоо	24
Дүрмийн сан	905,778,225 төгрөг
Хувьцааны тоо	34,452,124 ширхэг энгийн хувьцаа
Зах зээлийн үнэлгээ	4,477,742,556 төгрөг



ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН МЭНДЧИЛГЭЭ

Мэдээллийн технологийн салбарын хөгжлийн хурдасгуур болсон эрхэм хувьцаа эзэмшигч та бүхний энэ өдрийн амар амгаланг айлтган мэндчилж байна. 2018 оны өнгөрсөн хагас жилд Төлөөлөн удирдах зөвлөл болон баг хамт олныхоо хичээл зүтгэл, харилцагчдынхаа итгэл, хамтын ажиллагааны үр дүнд салбартаа тэргүүлэгчийн байр сууриа болон өмнөх ололт амжилтуудаа давуулан бататгаж ажилласан. Чанарт суурилсан үйлчилгээг гол болгож, компанийн засаглалын тогтолцоог тасралтгүй сайжруулан ажилласны үр дүнд Айтүүлс ХК-ийн борлуулалтын орлого өнгөрсөн оны мөн үеийнхтэй харьцуулахад 66.1% өсч, ашгийн маржин 3 дахин нэмэгдсэн төдийгүй

харилцагчдийн тоо 13.1% өссөн байна. Мөн компанийн хувьцаа нийт 8.3 сая ширхэг арилжаалагдсан үзүүлэлттэй гарлаа. Мэдээллийн аюулгүй байдал түүнийг бүрэн хангаж ажиллахын тулд техник, технологийн болон хүний нөөцийг чадамжийг нэмэгдүүлэх, бүтээгдэхүүн, үйлчилгээний чанараа дэлхийн энд зэрэгцүүлэхийн тулд зогсолтгүй хөгжиж цөөнгүй тооны төсөл хөтөлбөрүүдийг санаачлан хэрэгжүүлэхээр төлөвлөж байна. 2018 онд дэвшүүлсэн зорилго, зорилтдоо хүрэхийн тулд ирэх хагас жилд бид илүү ёс суртахуунтай, хичээл зүтгэлтэй бүтээлч ажиллаж мэдээллийн аюулгүй байдал түүний үнэ цэнийг улам нэмэгдүүлэн ажиллахаа энэ завшааныг ашиглан нийт хөрөнгө оруулагчиддаа болон дотоод, гадаадын харилцагчиддаа илэрхийлж байна. Та бүхэнд эрүүл энх, ажлын өндөр амжилт, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе!

“Айтүүлс” ХК-ийн гүйцэтгэх захирал

Б.ТАМИР

АЛСЫН ХАРАА

Дэлхийн жишиг дата төв болж бүтээгдэхүүн үйлчилгээгээ дэлхийд экспортолно.

ЭРХЭМ ЗОРИЛГО

Хэрэглэгчийн эрэлт хэрэгцээнд нийцсэн, зах зээлд өрсөлдөх чадвартай бүтээгдэхүүн үйлдвэрлэж, худалдах /үйлчилгээ үзүүлэх/ замаар ашигтай ажиллаж, хувьцаа эзэмшигчдийн хөрөнгийг өсгөж, тэдний ашиг сонирхлыг ханган ажиллах нь компанийн үндсэн зорилго мөн.

ЭРХЭМЛЭХ ҮНЭТ ЗҮЙЛС

- Компани төдийгүй эх орныхоо төлөө бие сэтгэл, мэдлэг чадвараа бүрэн дайчлан ажиллаж буй бизнесийн ёс зүйтэй баг, хамт олон
- Мэдээллийн технологийн үнэ цэнийг ойлгож үргэлж хамт байдаг хэрэглэгч, харилцагч, бизнесийн түншүүд
- Дэлхийд чанараар өрсөлдөх бүтээгдэхүүн, үйлчилгээ
- Харилцагчийн мэдээллийн аюулгүй байдал

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРЧИМ

- Ёс суртахуунтай, ил тод, нээлттэй
- Хууль, эрх зүйн хэм хэмжээг дээдэлнэ
- Мэдээллийн аюулгүй байдлыг чандлан сахина


УРИА ҮГ

Зогсолтгүй хөгжиж, амжилтаараа ялгаръя

МАНАЙ ХАМТ ОЛОН




КОМПАНИЙН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ



КОМПАНИЙ ЗАСАГЛАЛ

ЗАСАГЛАЛЫН ТОГТОЛЦОО


“Айтүүлс” ХК-ийн засаглалын тогтолцоо нь хувьцаа эзэмшигчид, удирдлагууд болон бусад оролцогч талуудын ашиг сонирхлын тэнцвэрийг хангаж, компанийн зорилт, үйл ажиллагааны үндсэн чиглэлийг тодорхойлох, хэрэгжүүлэх, хянахад чиглэсэн бүтэц, зохицуулалтын нийлбэр юм.



Манай компани шинэчлэн батлагдсан Компанийн тухай хууль, Монголын компанийн засаглалын кодекс, гаднын компаниудын сайн засаглалын туршлагаас судлан сайн засаглалыг нэвтрүүлэхээр ажиллаж байна.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИД

“Айтүүлс” ХК нь 2017 оны 11 дүгээр сард нийт хувьцааны 38.86%-ийг олон нийтэд нээлттэй болгосноор дараах хувьцаа эзэмшлийн бүтэцтэй болсон.



НИЙТ ХУВЬЦААНЫ ТОО: 34,452,124
 НИЙТ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ТОО: 1065
 /2018 оны 06 дугаар сарын 30-ны байдлаар/

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛ

“Айтүүлс” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн эрхээ хэрэгжүүлэх гол хэлбэр нь Хувьцаа эзэмшигчдийн хурал бөгөөд Хувьцаа эзэмшигчдийн хурал нь компанийн эрх барих дээд байгууллага байна. Компани Хувьцаа эзэмшигчдийн хурлаараа Компанийн тухай хуулийн 62.1-т заасан Хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхэд хамаарах болон ТУЗ-өөс эсвэл компанийн дүрмээр хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлж шийдвэрлэхээр тогтоосон компанийн удирдлага зохион байгуулалт, үйл ажиллагааны гол асуудлуудыг хэлэлцүүлэн шийдвэрлүүлдэг.

Анхдугаар хурал

“Айтүүлс” ХК Хувьцаа эзэмшигчдийнхээ анхдугаар хурлыг 2018 оны 01 дүгээр сарын 08-ны өдөр хувьцаа эзэмшигчдийн 63.3%-ийн ирцтэйгээр хуралдан дараах асуудлуудыг шийдвэрлэсэн болно. Үүнд:

1. Анхдагч зах зээлийн арилжааны тухай танилцуулгыг хийсэн.

“Айтүүлс” ХК нь 13,387,980 ширхэг хувьцааг нэгжийн үнэ 100 төгрөгөөр санал болгосон. “Айтүүлс” ХК-ийн анхдагч зах зээлийн арилжааны захиалгыг Монголын хөрөнгийн биржийн анхдагч зах зээлийн арилжааны системээр дамжуулан 2017.11.01-2017.11.10 өдрүүдэд авсан

бөгөөд 1,075 хөрөнгө оруулагчийн 39,789,996 ширхэг хувьцаа худалдан авах захиалга ирсэн байна. Үүнээс худалдан авахаар өгсөн захиалгандаа мөнгөний үлдэгдэл нь хүрэлцэхүйц 954 хөрөнгө оруулагчийн 37,978,448 ширхэг хувьцаа авах захиалга нь хүчин төгөлдөрт тооцогдсон болно. Энэ нь компанийн нийт татах 1,338,798,000 төгрөгийн үнийн дүнгээс 2.84 дахин давсан худалдан авах захиалга өгсөн байна.

2. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийг сонгосон.

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгохдоо кумулятив аргаар санал хураалт явуулан ТУЗ-ийн хараат бус гишүүнээр Монгол улсын иргэн З. Мягмарсүрэн, Д. Даваа, Л. Тэмүүлэл, Э. Наранмөнх нарыг, ТУЗ-ийн ердийн гишүүнээр И. Алтантулга Н. Улаанхүү, Г. Хатаболд, Б. Эрдэнэжаргал нарыг, ТУЗ-ийн даргаар А. Баттамирыг сонгохоор шийдвэрлэсэн.

3. Компанийн дүрмийг шинэчлэн баталлаа.

2018 оны 03 дугаар сарын 23-ны өдөр ТУЗ-ийн ээлжит хурал болж Б. Тамирыг “Айтүүлс” ХК-ийн Гүйцэтгэх захирлаар томилон ажиллуулахаар шийдвэрлэв

Ээлжит хурал

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2018 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр 21,155,025 саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн 61.4 хувийн ирцтэйгээр хуралдан дараах асуудлуудыг хэлэлцэж шийдвэрлэлээ.

1. Төлөөлөн удирдах зөвлөлөөс компанийн 2017 оны үйл ажиллагаа болон санхүүгийн тайлангийн талаар гаргасан дүгнэлтийг хэлэлцэн Төлөөлөн удирдах зөвлөлөөс “Айтүүлс” ХК-ийн гүйцэтгэх удирдлагын багийн ажлыг хангалттай” гэж дүгнэснийг 99%-ийн саналаар батлав.

2. Компанийн хэрэгжүүлж буй төсөл бүрэн дуусаагүйн зэрэгцээ компанийн үйл ажиллагааг өргөжүүлэх зорилгоор 2017 оны ашгаас ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэснийг танилцуулав.

3. Гүйцэтгэх захирал Б. Тамир компанийн 2018 оны үйл ажиллагааны ерөнхий төлөвлөгөөг танилцуулав.



НӨЛӨӨ БҮХИЙ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧ

№	Хувьцаа эзэмшигчийн нэр	Эзэмшиж буй хувьцааны тоо	Эзэмшиж буй хувьцааны хувь
1	"Ай Си Ти Групп" ХХК	21,064,144	61.14 %

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

“Айтүүлс” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл нь Хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт компанийн эрх барих байгууллага бөгөөд хувьцаа эзэмшигчдийн эрхийг хамгаалж, тэднийг төлөөлж компанийн үйл ажиллагааг ерөнхий удирдлагаар хангах, чиглүүлэх, үйл ажиллагаанд хяналт тавих, чиг үүргийг хэрэгжүүлдэг. ТУЗ-өөс жил бүр компанийн стратегийн зорилт, бизнес төлөвлөгөөг баталж, төлөвлөгөөний биелэлтийг сар тутмын тайлангаар хянан, холбогдох үүрэг, чиглүүлгийг өгч ажиллаж байна. Мөн дэргэдээ байнгын үйл ажиллагаатай Аудитын хороо, Нэр дэвшүүлэх хороо, Цалин урамшууллын хороодыг байгуулж, компанийн засаглалыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДЭРГЭДЭХ ХОРООД

Аудитын хороо

ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны зорилго нь байгууллагын нягтлан бодох бүртгэл, аудитын үйл ажиллагаа, санхүүгийн тайлагналын үнэн зөв байдал, компанийн дотоод хяналт, журмуудын нягтлан бодох бүртгэлийн стандарт, холбогдох хууль, дүрэмд нийцсэн байдал, эрсдэлийн удирдлагын бодлого, стратегийг тодорхойлох, эрсдэлийн удирдлагын хэрэгжилтэд хяналт тавих, хараат бус аудиторын мэргэжлийн ур чадвар, хараат бус байдлыг үнэлэх, сонгох зэрэг үйл ажиллагаанд хяналт тавих замаар Төлөөлөн удирдах зөвлөлийг хяналтын чиг үүргээ хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэхэд оршино.

Нэр дэвшүүлэх хороо

ТУЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хорооны зорилго нь компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийг ТУЗ-ийн гишүүд, Гүйцэтгэх захирал, бусад гүйцэтгэх удирдлагууд, эрх бүхий албан тушаалтнуудыг сонгон шалгаруулах, тэдгээрийн ажил үүргийг тодорхойлох, ажлын гүйцэтгэлийг үнэлэх чиглэлээр чиг үүргээ хэрэгжүүлэхэд нь туслахад оршино.

Цалин, урамшууллын хороо

ТУЗ-ийн дэргэдэх Цалин, урамшууллын хорооны зорилго нь компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийг ТУЗ-ийн гишүүд, Гүйцэтгэх захирал, бусад гүйцэтгэх удирдлагууд, эрх бүхий албан тушаалтнуудын цалин, урамшууллыг томъёолох, тогтоох, компанийн хэмжээнд цалин урамшууллын бодлогыг тодорхойлох, эдгээрийн талаар хууль, дүрэм, журамд нийцүүлэн санал, дүгнэлт гаргах чиглэлээр чиг үүргээ хэрэгжүүлэхэд нь туслахад оршино. 2018 оны эхний хагаст Төлөөлөн удирдах зөвлөл 4 удаа, Аудитын хороо 2 удаа, тус тус хуралдаж, холбогдох чиг үүргийн хүрээнд нийт 15 асуудлыг хэлэлцэж шийдвэрлэн, 9 тогтоол гарган, компанийн стратегийг тодорхойлж, үйл ажиллагааг чиглүүлэн, хяналт тавьж ажиллалаа.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Дарга



Адилбиш
БАТТАМИР

Техникийн ухааны магистр
Нэр дэвшүүлэх хорооны гишүүн

Хараат бус гишүүд:



 <p style="text-align: center;">Дамдинсүрэн ДАВАА</p> <p>-Програм хангамжийн инженер</p> <p>-ККТТ ХХК-ийн Бизнес хариуцсан захирал</p> <p>-Цалин урамшууллын хорооны гишүүн</p>	 <p style="text-align: center;">Зэсэм МЯГМАРСҮРЭН</p> <p>-Зах зээл судлаач, эдийн засагч</p> <p>-Бодьтусгал-Аудит ХХК-ийн захирал</p> <p>-Аудитын хорооны дарга, цалин урамшууллын хорооны гишүүн</p>	 <p style="text-align: center;">Энхтуяа НАРАНМӨНХ</p> <p>-Програм хангамжийн инженер</p> <p>-Грийнсофт ХХК-ийн Борлуулалт, маркетингийн албаны дарга</p> <p>-Нэр дэвшүүлэх хорооны гишүүн</p>	 <p style="text-align: center;">Лхагва ТЭМҮҮЛЭЛ</p> <p>Эрх зүйн ухааны магистр</p> <p>-Тэлмэнхас ББСБ-ийн Хувьцаа эзэмшигч</p> <p>-Нэр дэвшүүлэх хорооны дарга, аудитын хорооны гишүүн</p>
---	---	--	--

Ердийн гишүүд:

 <p>Идэрмөнх АЛТАНТУЛГА</p> <p>-Төрийн удирдлагын магистр</p>	 <p>Нанжид УЛААНХҮҮ</p> <p>-Эдийн засгийн онолч, эдийн засагч</p> <p>-Аудитын хорооны гишүүн</p>	 <p>Гантулга ХАТАНБОЛД</p> <p>Санхүүгийн удирдлагын магистр</p> <p>-Дижитал эксчейнж монголиа ХХК-ийн Гүйцэтгэх захирал</p> <p>-Цалин урамшууллын хорооны дарга</p>	 <p>Баярмагнай ЭРДЭНЭЖАРГАЛ</p> <p>-Бизнесийн удирдлага</p> <p>-Стандарт инвестмент ҮЦК ХХК-д диллер</p>
--	---	---	---

КОМПАНИЙН ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНУУД

	Овог Нэр	Албан тушаал	Мэргэжил, ажлын туршлага
	<p>Баярсайхан ТАМИР</p>	<p>“Айтүүлс” ХК-ийн Гүйцэтгэх захирал</p>	<p>Саман-Ёлу ХХК-д Захирлын туслах, Эмпати-Ертөнц ХХК-д нягтлан бодогч, Улаанбаатар-Элит ОУДС-д нягтлан бодогч, Татварын Ерөнхий газар-НӨАТ-ын төсөл-Ерөнхий санхүүч, Гааль Татварын мэдээллийн технологийн төв УТҮГ-т олон нийттэй харилцах мэргэжилтэн, Эмпасофт ХХК-д сургалт хариуцсан менежерээр тус тус ажиллаж байсан.</p> <p>2018 оны 04 дүгээр сарын 05-ны өдрөөс эхлэн ТУЗ-ийн 09 тоот тогтоолоор “Айтүүлс” ХК-ийн гүйцэтгэх захирлаар томилогдон ажиллаж байна.</p>

	<p>Цогттуяа ЦАЦРАЛГЭРЭЛ</p>	<p>Нягтлан бодогч</p>	<p>Монгол Сата Интернешнл ХХК-д нягтлан, Тавин-Ус ХХК-д Ерөнхий нягтлан бодогч, Энержи Ресурс ХХК-д ахлах нягтлан бодогчоор тус тус ажиллаж байсан.</p> <p>2016 оны 01 дүгээр сарын 22-ны өдрөөс эхлэн “Айтүүлс” ХК-ийн Нягтлан бодогчоор ажиллаж байна.</p>
	<p>Баянбат АРИУНЗУЛ</p>	<p>ТУЗ-ийн нарийн бичгийн дарга</p>	<p>БСШУСЯ-ны дэргэдэх Боловсролын үнэлгээний төвд Төсөл хөтөлбөр хариуцсан мэргэжилтэн, Дотоод асуудал хариуцсан мэргэжилтнээр тус тус ажиллаж байсан.</p> <p>2018 оны 02 дугаар сарын 08-ны өдрөөс эхлэн “Айтүүлс” ХК-ийн ТУЗ-ийн нарийн бичгийн даргаар ажиллаж байна.</p>

БИЗНЕСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДЛУУД



“ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙГ ХӨГЖҮҮЛЭГЧ” КОМПАНИАР ШАЛГАРЛАА

50 жилийн түүхтэй МҮОНРТ - Цагийн хүрд мэдээллийн хөтөлбөрийн хүрээнд тодруулагдсан “Цагийн хүрдийн баатрууд” хэмээх ёслол хүндэтгэлийн ажиллагаанд “Айтүүлс” ХК нь Мэдээлэл технологийн салбартаа анхдагч болж, “Хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэгч” компаниар шалгарлаа.



“АЙ СИ ТИ ГРУПП” ХХК БОЛОН “МТҮПАРК” ХАМТЫН АЖИЛЛАГАА ЭХЭЛЛЭЭ

Мэдээлэл технологийн үндэсний парк болон “Ай Си Ти Групп” ХХК, “Айтүүлс” ХК хамтын ажиллагааны гэрээнд гарын үсэг үзэглэснээр Блокчэйн технологи, Аутсорсинг хөгжүүлэх - хүний нөөц, гадаад зах зээлийг тэлэх, өндөр технологийн сургалт, судалгаа, хөгжүүлэлтийн төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлэх төслийг албан ёсоор эхлүүлээ.



“АЙТҮҮЛС” ХК-ийн ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ ШИНЭЭР ТОМИЛОГДЛОО

Мэдээллийн технологийн салбартаа Анхдагч үнэт цаас гаргагч “Айтүүлс” ХК-ийн гүйцэтгэх захирлаар 2018 оны 4 дүгээр сарын 5-ны өдрөөс Баярсайханы Тамир сонгогдож, томилогдон ажиллахаар боллоо. Тэрээр Нэмэгдсэн өртгийн албан татварын урамшууллын систем хөгжүүлэх төсөл /одоогийн Ebarimt/, Эмпасофт ХХК зэрэг мэдээллийн технологийн мега төсөл хөтөлбөрүүд болон компаниудад тус тус амжилттай ажиллаж байсан туршлагатай нэгэн юм.



ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДЫН ЭЭЛЖИТ ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАГДЛАА

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд 2018 оны 04 сарын 30-ний өдрийн байдлаар ITLS-г эзэмшигч буй хувьцаа эзэмшигч оролцож 90%-ийн иртэйгээр хурал хүчин төгөлдөр боллоо. Ээлжит хурлаар дараах асуудлуудыг хэлэлцэн баталлаа.

- 2017 оны үйл ажиллагаа болон санхүүгийн тайлангийн талаар
- Ноогдол ашиг хувиарлахгүй байх талаар
- 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгө



БЛОКЧЭЙН ТЕХНОЛОГИД СУУРИЛСАН ҮЙЛЧИЛГЭЭГ ЭКСПОРТЛОЖ ЭХЭЛЛЭЭ

“Айтүүлс” ХК нь Япон улсын мэдээллийн технологийн тэргүүлэх компани болох UNIMEDIA групп компанитай “Хамтын ажиллагааны гэрээ” үзэглэлээ. Энэхүү гэрээний хүрээнд “Айтүүлс” ХК-ийн олон улсын шаардлага хангасан дата төв болон блокчэйн технологид суурилсан майнинг фармд Японы “Unimedia” групп сервер, сүлжээний тоног төхөөрөмж болон крипто валют олборлох төхөөрөмжүүдийг байршуулахаар харилцан тохиролцсон болно.



МОНГОЛЫН ХУВЬЦААТ КОМПАНИУДЫН ХОЛБООНД НЭГДЛЭЭ

“Айтүүлс” ХК нь Монголын Хувьцаат Компаниудын Холбооны үндсэн гишүүнээр элсэж гишүүнчлэлийн гэрчилгээг хүлээн авлаа. Монголын Хувьцаат Компаниудын Холбоо нь Монгол улсад үйл ажиллагаа явуулж байгаа арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй, үнэт цаас нь нийтэд чөлөөтэй арилжаалагддаг компаниудын сайн дурын үндсэн дээр эвлэлдэн нэгдсэн нийгэмд үйлчилдэг төрийн бус байгууллага юм



ЯПОН УЛСЫН ЗАХ ЗЭЭЛД АЙТҮҮЛС ХК КЛОУДМАЙНИНГ ҮЙЛЧИЛГЭЭГ ЭКСПОРТОЛЖ ЭХЛЭЛЭЭ.

“Айтүүлс” ХК-ийн үндсэн үйлчилгээ болох клаудмайнинг буюу крипто валют олборлох үйлчилгээг Япон улсын мэдээллийн технологийн компани тэр дундаа блокчейн технологид суурилсан бүтээгдэхүүн үйлчилгээ үзүүлдэг “Гинко Монгол” компанитай бизнесийн үйл ажиллагааг өргөжүүлэх, шинэ бизнесийг эхлүүлэх, хамтран ажиллах талаар хамтын ажиллагааны санамж бичигт гарын үсэг зурлаа.



I EVENT УУЛЗАЛТ АМЖИЛТТАЙ ЗОХИОН БАЙГУУЛАГДЛАА

Блокчейн технологийн ирээдүйн хөгжил, түүний хэрэглээний талаар мэргэжлийн экспертүүдээс туршлага судлах, суралцах боломжийг I EVENT уулзалт бий болголоо. “Айтүүлс” ХК-наас мэдээллийн технологийн ирээдүйн хөгжил, шинэ содон технологийн талаар сонгосон сэдвийн хүрээнд мэргэжлийн экспертүүд өөрсдийн туршлага, тэднээс суралцах боломжийг олгох I EVENT уулзалт 6 сарын 14-ний өдөр “Мэдээллийн Технологийн Үндэсний Парк”-д зохион байгуулагдсан юм.



ЭРҮҮЛ МЭНДИЙН ОНОШЛОГОО ШИНЖИЛГЭЭНД БҮРЭН ХАМРАГДАВ.

"Гурван гал" эмнэлэгтэй хамтын ажиллагааны хүрээнд эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх иж бүрэн үзлэгт нийт ажилчдаа хамруулсан. Эрүүл биед саруул ухаан оршино.



ГАЛЫН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН СУРГАЛТАНД ХАМРАГДЛАА

Дата центр, Клауд фарм гэх мэт өдөр тутамдаа цахилгааны өндөр хэрэглээтэй байдаг технологийн багийнхан галын аюул, эрсдэлийн эсрэг авах арга хэмжээнүүдийн талаар сургалтад хамрагдлаа. -70 градусын хэмтэй гал унтраагуурыг бодитоор туршиж галын аюулын үед авах үйл ажиллагааны талаар суралцаж практик дээр туршив.



ХҮНИЙ НӨӨЦИЙН МЕНЕЖМЕНТИЙН УЛСЫН Х-Р ОЛИМПИАДАД ИВЭЭН ТЭТГЭГЧЭЭР ОРОЛЦЛОО

Монголын хүний нөөцийн менежментийн улсын олимпиад нь бизнес менежмент, эдийн засгийн чиглэлээр сургалт явуулдаг их дээд сургуулиудын дунд жил бүр зохион байгуулагддаг. Энэ жил “Дижитал зуунд - HR” уриатайгаар СЭЗИСургууль дээр 5-р сарын 4-5 өдрүүдэд явагдаж өндөрлөлөө. Олимпиадын зорилго нь Монголын оюутан залуусын мэдлэг чадварыг сорьж хөгжүүлэх замаар мэргэжлийн төвшинг нь дээшлүүлж, улс эх орныхоо шилдэг ажиллах хүчнийг бэлтгэх явдал юм.



IBM КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨГЧИД “АЙТҮҮЛС” ХК-Д ЗОЧИЛЛОО


Дэлхийн мэдээллийн технологийн тэргүүлэх компани болох IBM компанийн зочид төлөөлөгч нар “Айтүүлс” ХК-д зочиллоо.

Тус уулзалтанд IBM компанийн IBM CLOUD-ын дэд ерөнхийлөгч Wing Kin Cheung, WATSON & CLOUD PLATFORM -ын захирал James LIU, Бизнесийн хамтын ажиллагааны менежер Lawrence FU болон “Ай Си Ти групп” ХХК-ийн захирал Г.Лхамсүрэн “Айтүүлс” ХК-ны ТУЗ-ийн дарга А.Баттамир “Айтүүлс” ХК-ийн гүйцэтгэх захирал Б.Тамир нар оролцлоо.



Уулзалтын хүрээнд “Айтүүлс” ХК-ийн 2018 оны 9-р сард ашиглалтанд орох санхүүгийн дата төв болон блокчейн технологи дээр суурилсан бүтээгдэхүүн, үйлчилгээний үйл ажиллагаа хөгжүүлэлтийн явцтай танилцаж “Айтүүлс” ХК болон IBM компани хоорондын цаашдын хамтын үйл ажиллагааг өргөжүүлэх талаар санал солилцлоо.

Монгол улсад ихээхэн дутагдаж буй санхүүгийн дата өгөгдлийн аюулгүй байдал, блокчейн технологи дээр суурилсан дэд бүтэц хөгжүүлэлт дээр цаашид хамтран ажиллах болно гэдгээ IBM компанийн зочид, төлөөлөгчид илэрхийллээ.



САНХҮҮГИЙН ДАТА ТӨВИЙН ӨРГӨТГӨЛИЙН АЖИЛ ЭХЛЭЛЭЭ.

“Айтүүлс” ХК нь 2018 онд хэд хэдэн томоохон төсөл хэрэгжүүлж буйн нэг болох “Санхүүгийн дата төв”-ийн төсөл юм. Төсөл нь энэ оны намар 9 сард ашиглалтад орохоор төлөвлөгдөн барилгын ажил хийгдэж байна.



АЙТҮҮЛСИЙН ХАРИЛЦАГЧИД ХУР СИСТЕМД ХОЛБОГДОХОД ХЯЛБАР БОЛЛОО

Үндэсний Дата төв болон Айтүүлс ХК хооронд хамтран ажиллах санамж бичигт гарын үсэг зурлаа. Уг арга хэмжээнд Харилцаа Холбоо Мэдээллийн Технологийн Газрын дарга Б.Чинбат, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга Б.Бат-Эрдэнэ, Үндэсний дата төвийн захирал Б.Батжаргал, Харилцаа Холбоо Мэдээллийн Технологийн Газрын мэдээллийн технологийн бодлого зохицуулалтын хэлтэсийн дарга Б.Билэгдэмбэрэл болон бусад албаны хүмүүс оролцов.



Уг санамж бичгийн үндсэн зорилго нь Төрийн мэдээлэл солилцооны “ХУР” системийг хувийн хэвшлийн байгуулагуудад хүртээлтэй хурдан шуурхай хүргэх, цахим засаглалыг хөгжүүлэхээр хамтран ажиллана. Уг хамтын ажиллагааны хүрээнд:

Төрөөс иргэдэд чиглэсэн үйлчилгээг хүртээжтэй, түргэн шуурхай хүргэж, цахим засаглалыг хөгжүүлэх түүнтэй холбоотой ажлуудыг таниулах чиглэлээр олон нийтэд мэдээлэл, санамж, зөвлөмжүүдийг хүргүүлэх;

“Айтүүлс” ХК нь хувийн хэвшлийн ААНБ-уудад “ХУР” системийг нэвтрүүлэхтэй холбоотой техникийн нөхцөлөөр бүрэн хангаж, нэвтрүүлэх боломжийг бий болгох болон бусад ажлуудыг хэрэгжүүлэхээр болсон байна.

КОМПАНИЙН 2023 ОН ХҮРТЭЛХ ДУНД ХУГАЦААНЫ СТРАТЕГИЙН БОДЛОГО

БҮТЭЭМЖ, ЧАНАРЫН БОДЛОГО

Олон улсын чанарын удирдлагын тогтолцоо ISO9001;2015, ISO27001;2013 стандартуудыг нэвтрүүлж, хариуцлага, бүтээмжийн тогтолцоог сайжруулсанаар “Айтүүлс” ХК-ийн зах зээлд эзлэх байр суурийг нэмэгдүүлж, өргөжүүлнэ.

БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БОДЛОГО

Монгол улсын цаг уур, газар зүйн онцлог давуу талууд ашиглан олон улсын стандартыг хангасан бүтээгдэхүүн үйлчилгээгээр дотоодын зах зээлийг бүрэн хангаж, экспортыг эрчимтэй нэмэгдүүлэх бодлого баримтлана.

МЭДЭЭЛЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН БОДЛОГО

Мэдээллийн аюулгүй байдлыг сайжруулах зорилгоор хүний нөөц, техник технологи, үйл ажиллагааны олон улсын стандартуудыг нэвтрүүлэх.

МАРКЕТИНГИЙН БОДЛОГО

Хэрэглэгчийн сэтгэл ханамжид нийцэхүйц бүтээгдэхүүн, үйлчилгээг боломжит болон зорилтот зах зээлд нэвтрүүлэх, идэвхижүүлэх, хоногшуулах стратегийн дагуу түүний ялгарал, өвөрмөц шинж байдалд тулгуурлан борлуулалтыг нэмэгдүүлэх бодлого баримтлан ажиллана.

ХҮНИЙ НӨӨЦИЙН БОДЛОГО

Байгууллагын үнэт баялаг бүтээгч ажилтнаа эрхэмлэх, мэргэшсэн хүний нөөцийг тогтмол хөгжүүлэх, чадавхижуулах замаар хүний нөөцийн удирдлагыг цогцоор хэрэгжүүлэх, олон улсад хүлээн зөвшөөрөгдөхүйц ур чадвар бүхий баг хамт олныг бий болгох, тогтоон барих бодлого хэрэгжүүлэх.

ТӨЛӨВЛӨГӨӨ 2018 ОН

ГОЛЛОН АНХААРЧ АЖИЛЛАХ ЧИГЛЭЛҮҮД





ЗУРАГ 1.

- Олон улсын стандарт нэвтрүүлэх ажлын хүрээнд Европын сэргээн босголт, хөгжлийн банкны дотоодын зөвлөх компанийг сонгон, мэдээллийн аюулгүй байдлын болон чанарын удирдлагын тогтолцооны стандарт болох ISO:9001, ISO:27001-ийг тус тус үйл ажиллагаандаа нэвтрүүлэх бэлтгэл ажил хангагдаад байна.
- Харилцагчдын гомдлыг бууруулах ажлын хүрээнд харилцагчдад онлайн зааварчилгаа болон дата төвийн бүтээгдэхүүн, үйлчилгээний талаарх мэдлэг олгох зөвлөмжийг олон нийтийн сүлжээгээр болон дижитал маркетингийн аргыг ашиглан тасралтгүй хүргэж байна.
- Зах зээл дээр гаргаж буй бүтээгдэхүүн, үйлчилгээний үнийг тогтогтвортой барьж байна.



ЗУРАГ 2.

- Манай компанийн хэрэгжүүлж буй төслүүдийг нэг болох Модуляр дата төвийн Дархан хот дахь барилгын бүтээн байгуулалтын ажил хийгдэж байгаа бөгөөд энэ жилийн III-р улиралд ашиглалтад оруулахаар ажиллаж байна.
- Бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлж, шинэ бүтээгдэхүүн үйлчилгээ гарган, борлуулалт маркетингийн шинэ бодлого хэрэгжиж буйтай холбогдуулан нийт харилцагчийн тоо өмнөх оны мөн үеийнхээс 13.1 %-р өссөн буюу 6000 орчим, бүтээгдэхүүн үйлчилгээний борлуулалдсан тоо 13.800-д хүрсэн төдийгүй үндсэн үйл ажиллагааны борлуулалтын орлого 66.1%-р өссөн үзүүлэлттэй байна.
- 2018 онд ашгийн маржинг 2 дахин нэмэгдүүлэх зорилт тавьсан байсан бол 2018 оны эхний хагас жилийн байдлаар ашгийн маржин 3 дахин нэмэгдсэн үзүүлэлттэй байна.




ЗУРАГ 3.

- Мэдээллийн аюулгүй байдлын хүрээнд TIA 942 стандартыг нэвтрүүлж, мэргэжилтнүүдийг CISSP, CISM зэрэг сургалтуудад хамруулж, мэдээллийн аюулгүй байдлын бодлого, журмыг боловсруулан, үйл ажиллагаандаа тогтмол хэрэгжүүлж эхлээд байна.



ЗУРАГ 4.

- Маркетинг, борлуулалтын бодлогын хүрээнд экспортыг нэмэгдүүлэх ажлуудыг тодорхойлогдсон сегментүүдэд хийж байгаа бөгөөд дата төвийн үндсэн бүтээгдэхүүн үйлчилгээнээс гадна клоудмайнинг болон крипто фармийн экспортыг нэмэгдүүлэх бизнесийн төлөвлөгөөт ажлууд хийж, олон улсын компаниудтай хамтын ажиллагааг эхлүүлээд байна.



ЗУРАГ 5.

- Хүний нөөцийг олон улсын сертификаттай сургалтуудад хамруулж, чадавхижууллаа. Үүнд:
 1. "Envato Themeforest" олон улсын сертификатын сургалт
 2. "ITIL Foundation" Information technology Infrastructure Library сертификатын сургалт, шалгалт
 3. "CISM" ISACA сертификатын сургалт



ЗУРАГ 6.




ЗУРАГ 7.



ЗУРАГ 8.




ЗУРАГ 9.



ЗУРАГ 10.





ЗУРАГ 12.



ЗУРАГ 13.

БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭ

ДАТА ТӨВ

“Айтүүлс” ХК нь одоогоор 30 гаруй нэр төрлийн бүтээгдэхүүн үйлчилгээг гадаад, дотоодын зах зээлд нийлүүлж 6000 орчим харилцагчтай болоод байна.



Домэйн нэрийн бүртгэл
Domain Name Registration



Веб байршуулах үйлчилгээ
Web Hosting Services



Сервер байршуулах үйлчилгээ
Co-location Services




Интернет холболтын үйлчилгээ
Internet Service Provider



Борлуулалтын дараах
үйлчилгээ
Aftersales Services



Физик серверийн түрээс
Dedicated Server




Виртуал серверийн түрээс
Virtual Private Server



Сэцэн бизнес багц
Setsen Business Suite



БЛОК ЧЭЙН ТЕХНОЛОГИЙН НӨД
BLOCK CHAIN NODE



КРИПТО ФАРМ
CRYPTO FARM



ДАТА ОЛБОРЛОЛТ
DATA MINING

ШИНЭ БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛЧИЛГЭЭ

WAF (Вэб програмын галт хана)



WAF буюу Web Application Firewall нь вэбэд суурилсан аппликэйшн болон вэб серверүүдийг гадны халдлагаас хамгаална. Гаднаас орж ирэх HTTPS, HTTP, SMTP, PoP3 гэх мэт хүсэлтүүд дээр анализ хийж тогтоосон дүрмийн дагуу дотоод систем рүү нэвтрүүлэх ба нийтлэг байдаг SQL injection, XSS scripting болон Cross-Site халдлагаас хамгаалах боломжийг олгодог.

WAF-ийн IPS буюу Intrusion Prevention System нь сүлжээгээр урсах өгөгдлийн урсгалд дүн шинжилгээ хийж халдлагад өртөхөөс урьдчилан сэргийлдэг технологи юм. Ихэвчлэн Firewall Background Process түвшинд ажилладаг бөгөөд Firewall-аар дамжин орж байгаа

хориглосон, аюул учруулж болзошгүй контентуудад анализ хийх, зөвшөөрөгдөөгүй урсгалыг блок хийх маш том давуу талыг олгодог.

STARTUP & STANDUP багц үйлчилгээ



Гарааны бизнес эрхлэгч, жижиг дунд бизнес эрхлэгч нарт хамгийн их тулгамддаг асуудал бол байгууллага, бүтээгдэхүүн, үйлчилгээгээ танилцуулах веб хуудас, бусад байгууллагатай харилцах бизнес и-мэйл байдаггүй тул олон нийтэд танигдахад удаан, зах зээлд эзлэх байр суурийг илтгэж чадахгүй байна. Учир нь веб хуудас, веб хост, веб домэйн, бизнес и-мэйлийн үйлчилгээ нь гарааны бизнес эрхлэгч авахад хэт их үнэтэй, веб сайтын талаарх мэдээлэл хомс байдгаас үүдэлтэй.

Бид МОНГОЛДОО анх удаа зөвхөн Гарааны бизнес эрхлэгч болон Жижиг дунд бизнес эрхлэгчдэд зориулсан цоо шинэ үйлчилгээг хамгийн ХЯМД үнээр санал болгож байна.

САНХҮҮГИЙН ТАЙЛАН

ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

№	Үзүүлэлт	Өмнөх үеийн дүн	Тайлант үеийн дүн
1	Борлуулалтын орлого (цэвэр)	<u>1,333,663,971.57</u>	<u>404,909,333.60</u>
2	Борлуулалтын өртөг	851,449,899.49	72,658,161.48
3	Нийт ашиг (алдагдал)	<u>482,214,072.08</u>	<u>332,251,172.12</u>
4	Түрээсийн орлого	9,090,909.09	5,454,545.45
5	Хүүний орлого	1,147,298.06	166,034.28
6	Ногдол ашгийн орлого		
7	Эрхийн шимтгэлийн орлого		
8	Бусад орлого		
9	Борлуулалт, маркетингийн зардал		
10	Ерөнхий ба удирдлагын зардал	431,567,892.06	271,298,796.59
11	Санхүүгийн зардал		
12	Бусад зардал		
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	9,062,055.75	2,718,645.00
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	-
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)		
17	Бусад ашиг (алдагдал)		
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	<u>69,946,442.92</u>	<u>69,291,600.26</u>
19	Орлогын татварын зардал	6,994,644.29	6,929,160.03
20	Татварын дараах ашиг (алдагдал)	<u>62,951,798.63</u>	<u>62,362,440.24</u>
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)		
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	<u>62,951,798.63</u>	<u>62,362,440.24</u>
23	Бусад дэлгэрэнгүй орлого		
	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		
	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		
	Бусад олз (гарз)		
24	Орлогын нийт дүн		
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)		

ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

№	ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2017 оны 01-р сарын 01-ний үлдэгдэл	905,758,223	460,721,652	54,019,440	1,420,499,315
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга				-
3	Залруулсан үлдэгдэл	905,758,223	460,721,652	54,019,440	1,420,499,315
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)			62,951,799	62,951,799
5	Бусад дэлгэрэнгүй орлого				-
6	Өмчид гарсан өөрчлөлт				-
7	Зарласан ногдол ашиг				-
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн				-
9	2017 оны 12 -р сарын 31 -ний үлдэгдэл	905,758,223	460,721,652	116,971,238	1,483,451,114
1	2018 оны 01-р сарын 01-ний үлдэгдэл	905,758,223	460,721,652	116,971,238	1,483,451,114
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга				-
3	Залруулсан үлдэгдэл	905,758,223	460,721,652	116,971,238	1,483,451,114
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)			62,362,440	62,362,440
5	Бусад дэлгэрэнгүй орлого				-
6	Өмчид гарсан өөрчлөлт	1,338,798,000			1,338,798,000
7	Зарласан ногдол ашиг				-
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн				-
9	2018 оны 06 -р сарын 30 -ний үлдэгдэл	2,244,556,223	460,721,652	179,333,679	2,884,611,554

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН


№	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	0	0
1.1	Мөнгөн орлогын дүн	1,476,121.30	445,400.30
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	1,467,030.40	445,400.30
1.1.2	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	0	0
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	0	0
1.1.4	Буцаан авсан албан татвар	0	0
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого	0	0
1.1.6	Бусад мөнгөн орлого	9,090.90	0
1.2	Мөнгөн зарлагын дүн	1,373,439.50	300,748.10
1.2.1	Ажиллагчдад төлсөн	130,755.30	47,149.80
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	27,676.30	34,733.00
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	863,950.10	72,658.20
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	4,496.60	4,855.20
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	0	0
1.2.6	Хүүний төлбөрт төлсөн	0	0
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	24,928.00	6,820.50
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	0	0
1.2.9	Бусад мөнгөн зарлага	321,633.20	134,531.40
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	102,681.80	144,652.20
2	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	0	0
2.1	Мөнгөн орлогын дүн	1,147.30	166
2.1.1	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	0	0
2.1.2	Биет бус хөрөнгө борлуулсны орлого	0	0
2.1.3	Хөрөнгө оруулалт борлуулсны орлого	0	0
2.1.4	Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого	0	0
2.1.5	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	0	0
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого	1,147.30	166
2.1.7	Хүлээн авсан ногдол ашиг	0	0
2.1.8		0	0
2.2	Мөнгөн зарлагын дүн	1,046,807.30	426,306.60
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	1,046,807.30	291,886.80
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	0	81,553.80
2.2.3	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	0	0
2.2.4	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	0	0

2.2.5	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	0	52,866.00
2.2.6		0	0
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-1,045,660.00	-426,140.60
3	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	0	0
3.1	Мөнгөн орлогын дүн	1,338,798.00	0
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	1,338,798.00	0
3.1.2	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	0	0
3.1.3	Төрөл бүрийн хандив	0	0
3.1.4		0	0
3.2	Мөнгөн зарлагын дүн	0	116,158.20
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	0	116,158.20
3.2.2	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн	0	0
3.2.3	Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн	0	0
3.2.4	Төлсөн ногдол ашиг	0	0
3.2.5		0	0
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	1,338,798.00	-116,158.20
4	Валютын ханшийн зөрүү	0	2,718.60
4.1	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	395,819.80	-394,928.00
5	МӨНГӨ, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГИЙН ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ	16,189.00	412,008.80
6	МӨНГӨ, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГИЙН ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ	412,008.80	17,080.80

САНХҮҮГИЙН ШИНЖИЛГЭЭ

Санхүүгийн шинжилгээний үзүүлэлт	Улирлаар	
	06/31/17	2018-06-30
Хөрвөх чадварын харьцаа		
Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа=(Эргэлтийн хөрөнгө-Бараа материал)/Эргэлтийн эх үүсвэр	0.97	2.07
Төлбөрийн чадварын харьцаа		
Өрийн харьцаа=Нийт өр төлбөр/Нийт хөрөнгө	0.14	0.11
Үйл ажиллагааны харьцаа		
Дансны авлагын эргэц=Борлуулалт/Дансны авлагын дундаж хэмжээ	3.57	23.36
Ашигт ажиллагааны харьцаа		
Цэвэр ашгийн ахиуц=Татварын дараах цэвэр ашиг/Борлуулалтын орлого	0.05	0.15
Нийт ашгийн ахиуц=Нийт ашиг/Борлуулалт	0.78	0.82
Үйл ажиллагааны ашгийн ахиуц=Үйл ажиллагааны ашиг/Борлуулалтын орлого	0.05	0.17
Нийт хөрөнгийн өгөөж (ROA)=Татварын дараах цэвэр ашиг/Нийт хөрөнгийн дундаж хэмжээ	0.67%	1.92%
Эзэмшигчийн өмчийн өгөөж (ROE)=Татварын дараах ашиг/Дундаж эзэмшигчдийн өмч	0.78%	2.16%

ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ БА ХУВЬЦАА



Эх сурвалж: http://mse.mn/uploads/ariljaa/reports/report_mn-21.pdf

Зах зээлийн үнэлгээ
4,457,071,281.88

Нийт хувьцаа эзэмшигчид
1065

Нийт хувьцааны тоо
13,387,980

Хөрөнгийн биржийн 2018 оны эхний хагас жилийн тайланд тусгагдсанаар "Айтүүлс" ХК нь 2.000.662 хувьцаа арилжаалагдсан.

Идэвхтэй арилжаалагдсан 20 үнэт цаас - "Айтүүлс ХК" 10-т эрэмбэлэгдсэн

Хагас жилийн санхүүгийн шинжилгээний үндсэн үзүүлэлтүүд

Айтүүлс ХК	EPS, MNT	Close price, 27.07.2018	P/B	P/E	ROA	ROE	Зах зээлийн үнэлгээ, тэрбум
2018/2Q	1.81	130	1.55	71.80	1.92%	2.16%	4,478
2017/2Q	0.53	100	1.47	188.78	0.67%	0.78%	2,106

ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ХУВЬЦААНЫ АРИЛЖААНЫ МЭДЭЭ

Үзүүлэлт	2018.06.30
Нийт гаргасан хувьцааны тоо (ширхэг)	13,387,980
Төрөл	Энгийн хувьцаа
Хувьцааны үнэ (төгрөг)	131
Хаалтын үнэ	130
Хамгийн их үнэ	185
Хамгийн бага үнэ	117
Дундаж үнэ	139
Арилжаалагдсан тоо (ширхэг)	2,000,662
Арилжааны үнийн дүн (төгрөг)	287,560,554.72₮